



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

### ┌ Сургалт зохион байгуулах тухай ┐

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5 дахь заалт, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хотын аяллын хөтөч, тайлбарлагч нарт зориулсан “Музейд тайлбар хийх ур чадвар” сэдэвт сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 248,500 / хоёр зуун дөчин найман мянга таван зуун/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.


3. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын  
2015 оны 04 сарын 17-ний өдрийн (13) тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт



**“МУЗЕЙД ТАЙЛБАР ХИЙХ УР ЧАДВАР”  
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

**Зорилго:** Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг музей, үзвэрийн газарт тайлбар, танилцуулга хийж буй хөтөч-тайлбарлагч, орчуулагч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд сургалтын зорилго оршино.

**Сургалтын хөтөлбөр:**

		<b>ХӨТӨЛБӨР</b>	
<b>Баасан гариг</b>  <b>2015.04.17</b>	09:00-09:10	<b>Нээлт:</b> Нийслэлийн Аялал жуулчлалын газар ҮГТМузейн захирал Ч.Дариймаа	
	09:10-09:55	<b>Соёлын аялал жуулчлалын тухай ерөнхий ойлголт</b>	СУИС, Соёл боловсролын сургуулийн багш, доктрант <b>Ч.Мөнхжаргал</b>
	10:00-10:45	<b>Хөтөчийн ёс зүйн тухай</b>	СУИС, Соёл боловсролын сургуулийн багш, доктрант <b>Ч.Мөнхжаргал</b>
	10:50-11:10	Цайны завсарлага	
	11:15-12:00	<b>Палеонтологийн шинжлэх ухаан түүний судлах зүйл, малтмалын ангилал, хадгалагдах зүй тогтол, салбарууд, ач холбогдол</b>	ШУТИС, Геологи уул уурхайн сургуулийн ахлах, багш доктор <b>Г.Сэрсмаа</b>
	12:05-12:50	<b>Үлэг гүрвэлийн тухай, Монголын үлэг гүрвэлийн судалгаа, гол олдворт газрууд, үнэт олдворын талаар</b>	ШУТИС, Геологи уул уурхайн сургуулийн ахлах, багш доктор <b>Г.Сэрсмаа</b>
	12:50-13:00	Цайны завсарлага	
	14:00-14:45	<b>Музейн боловсролын хөтөлбөрийн талаар</b>	Үндэсний музейн боловсролын ажилтан <b>Венди Моррисон</b>
	14:50-15:35	<b>ҮГТМузейн танилцуулга, музейн өмнөх болон одоо явуулж буй үйл ажиллагааны талаар</b>	ҮГТМузейн ЭША <b>М.Булганцэнгэл</b>
	15:35- 15:50	Асуулт хариулт	
	15:50-16:10	<b>“Үлэг гүрвэлийн мөрөөр” үзэсгэлэнг танилцуулах</b>	ҮГТМузейн тайлбарлагч <b>Б.Төгсжаргал</b>

16:10-16:25 Гэрчилгээ гардуулах

16:25-17:00 Зураг авахуулах

**Хамрах хүрээ:** Хотын аяллын хөтөч тайлбарлагч нар хамрагдана.

**Зохион байгуулагч:** Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Үлэг гүрвэлийн төв музей


**Хугацаа:** 2014 оны 04-р сарын 17-ны өдөр 09.00-17.00 цагт зохион байгуулна.

**Хүрэх үр дүн:** Улаанбаатар хотын аялал жуулчлалын үзмэр, үзвэрийн газруудыг тайлбарлах хөтөч-тайлбарлагч нарын ур чадвар сайжирснаар хотын аяллын бүтээгдэхүүнийг сонирхох жуулчдын сонирхол, үнэлэмж дээшилнэ.

**Хаана болох:** Үлэг гүрвэлийн төв музейд

**Бүртгэх газар:** Үлэг гүрвэлийн төв музей

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын  
20.15 оны 09 сарын 17-ний өдрийн 13.1 тоот  
тушаалын хоёрдугаар хавсралт



“МУЗЕЙД ТАЙЛБАР ХИЙХ УР ЧАДВАР”  
СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Багшийн сургалтын төлбөр /СУИС, Соёл боловсролын сургуулийн багш, докторант Ч.Мөнхжаргал /	2 акад/цаг	35,000	70,000
2	Багшийн сургалтын төлбөр /ШУТИС, Геологи уул уурхайн сургуулийн ахлах, багш доктор Г.Сэрсмаа/	2 акад/цаг	35,000	70,000
3	Багшийн сургалтын төлбөр /Үндэсний музейн боловсролын ажилтан /Венди Моррисон/	1 акад/цаг	56,000	56,000
4	Гэрчилгээ	30	1750	52 500
	<b>Нийт дүн</b>			<b>248,500</b>

ТӨСӨВ ЗОХИОСОН:  
НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ш.УНДАРМАА

ХЯНАСАН:  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА